



ХЭНТИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

ЧИНГИС ХОТ

2015 ОН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН

ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Гэрээний агуулга, зорилт

“Хэнтий аймгийн Статистикийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө ” нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт болон тусгай ажил үйлчилгээнүүд, манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав. Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж , төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.Талуудын хүлээх үүрэг

Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг				
№	Үүрэг	Биелэлт	хувь	оноо
1.1	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө ”-нд тусгагдсан нийт 23 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт 23 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлж ажиллаа. 2015 онд Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай А/6 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 53 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 44 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 6 судалгааг 7388 гаруй мэдээлэгчдээс давхардсан тоогоор 9798 удаа авч шалгаж боловсруулан 262 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 262 удаа холбогдож графикт хугацаанд бүрэн дамжууллаа. /Дэлгэрэнгүйг тайланд тусгав/		

<p>1.2</p>	<p>Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон (2.24, 2.25, 2.26) тусгай 3 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.</p>	<p>Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон (2.24, 2.25, 2.26) тусгай 3 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлсэн.</p> <p>2.24. 2015 онд Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай А/6 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 53 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 44 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 6 судалгааг 7388 гаруй мэдээлэгчдээс давхардсан тоогоор 9798 удаа авч шалгаж боловсруулан 262 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 262 удаа холбогдож графикт хугацаанд бүрэн дамжууллаа.</p> <p>2.25. ҮСХ-ноос шаардсан графикт тусгаагүй мэдээ тайлан судалгааг цаг тухайд нь хугацаа хоцроолгүй шаардлагын түвшинд хийж мэйлээр, файл болон цаас хэлбэрээр бэлтгэж нийт 20 удаа ҮСХ-нд хүргүүлж ажиллалаа.</p> <p>ҮСХ-ноос ирүүлсэн аймгийн хэмжээний хадгаламж зээлийн үлдэгдлийг 2014 оны байдлаар гаргах судалгааг 18 сумдаар Монгол банкнаас гаргуулан авч хугацаанд нь хүргүүллээ.</p> <p>"Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жендэрийн төлөв байдлаар тодорхойлох нь" туршилтын судалгааны багт орж Хэрлэн, Бор-Өндөр, Батноров, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдад очиж ажиллалаа. Уг судалгаанд манай аймгаас 5 сумын 12 багын нийт 216 өрх сонгогдож судалгаа амжилттай явагдсан.</p> <p>Жижиглэн болон бөөний худалдааны салбарын үнийн мэдээнд ашиглах бараа бүтээгдэхүүнийг сонгох зорилгоор тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудаас нэг удаагийн түүвэр судалгааг өгөгдсөн маягт зааврын дагуу холбогдох мэдээллийг нийт 27 аж ахуйн нэгж байгууллагаас авлаа.</p> <p>Худалдааны салбарын үнийн индексийн тооцоонд ашиглах суурь үнэ цуглуулах судалгаанд 16 аж ахуйн нэгж сонгогдож эдгээр нэгжээс улирал бүр үнэ цуглуулан ҮСХ-нд дамжууллаа.</p>		
------------	---	---	--	--

ҮСХ-ны даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 1/134 тоот тушаалаар шинэчлэн баталсан Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) болон Үндэсний нийт орлого (ҮНО) тооцох аргачлалд “Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ, малын ашиг шимийн судалгааг 5 жил тутам явуулж, судалгааны дүнг ҮСХ-ны даргын шийдвэрээр баталгаажуулж, тооцоонд ашиглана” хэмээн заасаны дагуу энэ онд, МАШГТС-г 2015 оны 5-р сарын 1-нээс 11-р сарын 15-ны хооронд Дадал, Баян-овоо, Жаргалтхаан ХААБҮҮС-г 2015 оны 1-р сараас 12-р сарын хооронд Дадал, Баян-овоо, Жаргалтхаан 3 сумын 31 өрх 22 аж ахуйн нэгжээс авч нэгтгэлээ.

Аймгийн хэмжээнд лангуу, чингэлэг, гутал хувцас засвар, авто засвар эзэмшигч, түрээслэгч 377 иргэдийн судалгааг татварын хэлтсээр гаргуулан ҮСХ-д дамжууллаа.

60-с дээш настай – 9167 иргэд, 90-с дээш настай – 133 иргэдийн судалгааг гаргаж дамжуулав.

Аймгийн хэлтэс, тасаг, агентлагуудын тоог гаргаж ҮСХ-д явуулсан.

2.26. 60-с дээш настай – 9167 иргэдийн судалгааг гаргаж Аймгийн ИТХ, АЗДТГ-т гаргаж өглөө.

Хэнтий аймгийн хүн ам, өрх, нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийг аймгийн ЗДТГ, нийгмийн даатгалын хэлтэст гаргаж өгсөн. Хүн ам, өрхийн судалгааг шаардлагатай газруудад 20 удаа гаргаж өгөв.

Аймгийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар, хүн амын шилжилт хөдөлгөөнийг сүүлийн 10 жилээр аймгийн засаг дарга болон агентлагуудад гаргаж өглөө.

Нийгмийн бодлогын хэлтэст эмэгтэйчүүдийн судалгаа гаргаж өгөв.


Мянгат малчдын судалгааг АЗДТГ болон шаардлагатай газруудад 6 удаа гаргаж өгсөн.

Малын тоог урдчилсан байдлаар АЗДТГ-т гаргаж өгөв.

Махны жижиглэн болон бөөний үнийн судалгааг Хууль зүйн хэлтэст гаргаж өгсөн.

"Хэнтий мэдээ" сонинд статистик мэдээллийн булан нээж 7 хоног бүр тоо мэдээлэл өгөн ажиллаж байна. Мэдээг хавсаргаж оруулав.

/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/



1.3 Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Манлайллын зорилт **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ**

1.3.1 Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:

Зорилт -1: Статистикийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

Зорилт -2: Төрийн захиргааны албан хаагчийн албаны үйл

Хэнтий аймгийн ЗДТГазрын Дотоод Хяналт үнэлгээний шалгалт оруулж хэлтсийн бүх бичиг баримтанд хяналт үнэлгээ хийлгэж хангалттай гэсэн үнэлгээ авлаа.

АЗДТГ-аас боловсруулсан сумдын засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээг дүгнэх журманд хавсралт болгон 3 ерөнхий үзүүлэлт орууллаа.

Статистикийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд хэлтсийн дарга 1, мэргэжилтэн 3, гэрээт мэргэжилтэн 2, түүвэр судалгааны ажилтан 2, жолооч 1, нийт 9 хүний анкетыг шивж оруулсан.

Хэлтсийн ажилтнуудын 2015 оны үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж мэргэжилтэн А.Наранчимэг, Г.Сэдэдмаа, Ц.Батхишиг нар "А" үнэлгээ, гэрээт ажилтан Б.Онончимэг, Д.Мандахнаран нар хангалттай гэсэн үнэлгээ авлаа.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хаалтын ажиллагааны хүрээнд "Өөдрөг амьдралд тэмүүлсэн он жилүүд" нэгдсэн арга хэмжээнүүдэд хэлтсийн хамт

	ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлнэ.	олон бүрэн оролцлоо.		
1.3.2	<p>Байгууллагын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт -1: Хэнтий аймгийн Статистикийн хэлтсийн цахим хуудасны хэрэглэгчийн хүрээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг сурталчилах</p> <p>Зорилт -2: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах</p> <p>Зорилт -3: Орон нутагт Статистикийн үйл ажиллагааг гардан зохион байгуулж байгаа ажилтан нарт харилцах үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>Хэвлэлийн бага хурлыг сар бүрийн 15-наас 20-ны хооронд тогтмол хийж хэвшлээ. Үүнд аймгийн “Хэнтий” , “Өндөрхаан” телевизүүд, Хэнтийн мэдээ сонинг тогтмол оролцуулж байна. Хэвлэлийн бага хурлаар сар бүрийн гаргадаг танилцуулга, цаг үеийн ажлын талаар мэргэжилтнүүд ээлжлэн оролцож нийт 12 удаа мэдээлэл хийлээ.</p> <p>ӨНЭЗС болон АХС-ны шторкыг “Хэнтий”, “Өндөрхаан” телевизүүдэд өгч 15 хоног өдөрт 10 удаагийн давталттайгаар 150 удаа эфирээр, Мал тооллого, ХАОСЗТ-н шторкыг “Өндөрхаан”, “Хэнтий” телевизүүдээр болон facebook хуудсаар өдөрт 10 удаагийн давталттайгаар сард 15 хоног буюу давхардсан тоогоор 1500 удаа эфирээр цацууллаа.</p> <p>Интернэт хэрэглэдэг хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаар сар бүр орж мэдээлэл авч байх талаар зөвлөмж өгч ажиллаа. Интернэтгүй хэрэглэгчдэд Devinfo сангийн хэрэглэгээг сурталчилах зорилгоор monsis 1212 cd 70 ширхэгийг тархаалаа. Аймгийн ЗДТГ-ын үүдэнд байршуулсан цахилгаан самбарыг тогтмол шинэчилж мэдээллээр хангаж ажиллалаа.</p> <p>Статистикийн тухай хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчилах ажлын хүрээнд "Хэнтийн мэдээ" сонины эрхлэгч Д.Одонтунгалаг, Статистикийн хэлтсийн дарга Д.Болдбаатар нар 2015 онд хамтран ажиллах гэрээ байгуулав. Ингэснээр 7 хоног тутам гардаг тус сонинд статистик мэдээллийн булан тогтмол ажиллаж, иргэд аймаг орон нутгийн талаарх төрөл бүрийн тоо баримт мэдээлэлтэй танилцах боломжтой болсон.</p> <p>Хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон лекц хэлбэрээр 18 сум 4 тосгоныг оролцуулан 90 аж ахуйн нэгж, 14.0 мянган хүнд сургалт сурталчилгааг хийсэн.</p> <p>Статистикийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд аймгийн 22 санхүүгийн албаны мэргэжилтэн, 88 багийн засаг дарга, хэлтсийн албан хаагчдын анкетийн</p>		

		<p>өөрчлөлтийг шинэчлэн шивж оруулсан байна.</p> <p>Байгууллагынхаа мэргэжилтэн, тоологч нарын бичиг баримтад үзлэг хийж, зөрчлийг арилгуулан бүрдүүлэв. Хэлтсийн мэргэжилтэн, гэрээт ажилтан нартай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан бөгөөд гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллаа.</p> <p>Хэлтсийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн мэргэжилтнүүдийн жилийн бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөө, сар, улирал, 7 хоногийн төлөвлөгөөг батлан, гүйцэтгэлийг тухай бүр гаргуулан ажиллалаа. 2015 онд статистикийн хэлтсийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж холбогдох гэрээт ажилтан, тоологч, жолооч нарыг ҮСХ-той журмын дагуу зөвшилцөн томилж ажиллалаа.</p>		
1.3.3	<p>Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар :</p> <p>Зорилт -1: Санхүүгийн талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх</p> <p>Зорилт -2: Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг ил тод мэдээлэх</p>	<p>Үндсэн дансны жилийн батлагдсан төсөв нь 69268.6 мян.төгрөг. Уг төсөв нь 2015 оны 10-р сарын төсвийн тодотголд орж 67840.5 мян.төг болон танагдсан. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 56797.9 мян.төг, нийгмийн даатгалын шимтгэлд 5844.5 мян.төг, бараа үйлчилгээний зардалд 3795.7 мян.төг, тээврийн хэрэгслийн зардалд 1402.4 мян.төг зарцуулаад байна.</p> <p>Харин нэмэлт санхүүжилтийн данс буюу судалгааны зардлыг нэг бүрчлэн гүйцэтгэлээр нь харахад ӨНЭЗС, АХС-ны зардалд 31887.4 мян.төг, цаг ашиглалтын судалгаанд 8546.2 мян.төг, сургалтын зардалд 960.0 мян.төг, малын ашиг шимийн судалгаанд 1194.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 10608.5 мян.төг, жилийн эцсийн мал тооллогонд 3600.0 мян.төг, бусад төрлийн үнийн мэдээнд 2351.0 мян.төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>2014 оны санхүүгийн шалгалт болох мэргэжлийн хяналтын болон аудитын газрын шалгалтанд орж зөрчилгүй гэсэн дүгнэлт авсан.</p> <p>Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны тоологч нар судалгааг хэрхэн зохион байгуулж байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаанд хамрагдсан өрхүүдэд очиж судалгааны дэвтрийн хөтлөлтийн байдалтай танилцаж, өрхөд олгож буй урамшууллын мөнгө өрхөд олгогдсон эсэхийг баримттай нь тулган шалгах ажлыг сар бүр судалгаанд хамрагдсан бүх суманд хийлээ. ӨНЭЗСудалгаанд хамрагдсан 18 сумын 48 багийн 408 өрхийн 120 өрхөд, АХСудалгаанд хамрагдсан 18 сумын 36 багийн 432 өрхийн 120 өрхөд,</p>		

		<p>ЦАСудалгаанд хамрагдсан 8 сумын 16 багийн 320 өрхийн 100 өрхөд хяналт хийж судалгааны чанар, үнэн зөв байдал, өрхөд олгогддог урамшууллын мөнгө очиж байгаа эсэхийг шалгаж, судалгааны тоологч нарын ажлын чанарт үнэлгээ өгч ажиллаж байна.</p> <p>Хэлтсээрээ бие дааж хийсэн шалгалт аж ахуйн нэгжид 52, ӨНЭЗС, АХС-ны мониторингоор 840 өрхөөс 240 өрхөд, малын тооны хяналтаар 652 өрхөд, аймгийн бусад байгууллагатай хамтарсан шалгалт 40-ыг хийлээ.</p>		
1.3.4	<p>Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</p> <p>Зорилт -1: Хэлтсийн биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах</p> <p>Зорилт -2: Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх</p> <p>Зорилт -3: Хэлтэст нэн шаардлагатай эд хөрөнгийг ҮСХ болон орон нутгийн төсөвт тусгуулж олж авах</p>	<p>2015 онд ХАОСЗТ-н зардлаар үзүүлэлт сайтай 1 шинэ компьютер, нөүтбүк 1, зургийн аппарат 1, өнгөт принтер 1 тус тус худалдан авч мэргэжилтнүүдийг ажиллах таатай нөхцлөөр хангалаа.</p> <p>Эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хагас , бүтнээр тоолон бүртгэж шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг Аймаг, ҮСХ-нд гаргаж өгсөн. Хэлтсийн 2 машин хэвийн ямар нэгэн эвдрэл гэмтэлгүй ажиллаж байна.</p> <p>АЗДТГ болон ард иргэдийг мэдээллээр шуурхай хангах зорилгоор тамгын газрын байранд мэдээллээр үйлчлэх электрон самбарыг байрлуулж сар бүр мэдээллийг шинэчлэн байршуулж байна.</p> <p>ҮСХ-оос Видео хурал зарласан тухай бүрд техник хэрэгслэлийг бэлэн байдалд бэлтгэн оролцож, мэдээлэл хүлээн авч байлаа.</p> <p>Хэлтсийн 3 өрөөг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулж цэцэгжүүлж ажиллах нөхцлийг сайжрууллаа.</p> <p>2015 онд 6 төрлийн сургалтыг зохион явуулж нийт 377 хүнийг хамруулав. Сумдын санхүүгийн албаны дарга болон санхүүгийн албаны мэргэжилтэн нарын сургалтыг 2015 оны 03-р сарын 19 ны өдөр зохион явууллаа. Сургалтанд 18 сумын 22 санхүүгийн албаны дарга, 17 сумын санхүүгийн албаны мэргэжилтэн нар оролцож нийт 39 хүн хамрагдав. Сургалтаар Статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд өөрсдийн хариуцсан мэдээ, судалгаа, графикийн талаар дэлгэрэнгүй илтгэл тавьж санал солилцов.</p> <p>Багийн засаг дарга, тоо бүртгэгч нарын сургалт /БХСС/ - 2015 оны 2 дугаар сарын 09 нд Сумдын багийн засаг дарга нарын сургалтыг зохион байгуулж хэлтсийн дарга Д.Болдбаатар, мэргэжилтэн Ц.Батхишиг мэргэжилтэн А.Наранчимэг нар лекц уншиж мэргэжилтнүүд өөрсдийн ажлын чиглэлээр мэдээлэл хийлээ. Сургалтанд 18 сумын 22 санхүүгийн албаны мэргэжилтэн, 88</p>		

		багийн засаг дарга, аймгийн төвийн 8 багийн тоо бүртгэгч нар оролцож 117 хүн сургалтанд хамрагдлаа. /Дэлгэрэнгүйг тайланд тусгав/		
1.3.5	<p>Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар:</p> <p>Зорилт -1: Хэлтсийн мэргэжилтнүүдэд шилжилт хөдөлгөөн орж байгаатай холбогдуулан ҮСХ –той хамтран чадварлаг мэргэжилтэн олж ажиллуулах</p> <p>Зорилт -2: Орон нутгийн болон ҮСХ-ны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг гадаад, дотоод, сургалтанд оролцуулах</p> <p>Зорилт -3: Хэлтсийн ажлын байранд сургалтыг зохион байгуулах</p>	<p>ҮСХ-ноос зохион явуулдаг Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын анхан шатны сургалтанд хэлтсийн мэргэжилтэн А.Наранчимэг хамрагдаж А /93/ үнэлгээ аван сертификат гардан авлаа.</p> <p>2015 оны 4 дугаар сарын 28, 29 - ний өдрүүдэд Чингис хотноо зохион байгуулагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудийн нэгдсэн сургалт зөвлөгөөнд хэлтсийн мэргэжилтэн Г.Сэдэдмаа хамрагдсан.</p> <p>2015 оны 2 дугаар сарын 09 нд Сумдын багийн засаг дарга нарын сургалтыг зохион байгуулж хэлтсийн дарга Д.Болдбаатар, мэргэжилтэн Ц.Батхишиг мэргэжилтэн А.Наранчимэг нар лекц уншиж мэргэжилтнүүд өөрсдийн ажлын чиглэлээр мэдээлэл хийлээ. Сургалтанд 18 сумын 22 санхүүгийн албаны мэргэжилтэн, 88 багийн засаг дарга, аймгийн төвийн 8 багийн тоо бүртгэгч нар оролцож 117 хүн сургалтанд хамрагдлаа.</p> <p>Монгол улсад Статистикийн байгууллага үүсч хөгжсөний 91 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Хэнтий аймгийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад зориулсан “ Статистикийн боловсрол” сэдэвт хичээлийг зохион явууллаа. Сургалтанд Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р дунд сургуулийн төгсөх ангийн сурагчдын төлөөлөл 18 сурагч, 2-р дунд сургуулийн төгсөх ангийн сурагчдын төлөөлөл 21 сурагч, 3-р дунд сургуулийн 22 сурагч, 4-р дунд сургуулийн 20 сурагчид 4 багш нарын хамт нийт 85 хүн, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөх ангийн 3 бүлгийн 52 суралцагчид тус тус хамрагдлаа.</p> <p>/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/</p>		
1.4	Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурьдсан зорилтыг хэрэгжүүлнэ.			
	Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт	ҮСХ-ноос болон орон нутагт зохион байгуулагдаж байгаа сургалтанд хэлтсийн дарга, мэргэжилтэн, судлаачид хамрагдаж бүтэн жилийн турш сурсан бүх л Онлайн программ, Таблет, I PAD зэргийг бүрэн эзэмшиж ашиглаж мэдлэг		

<p>Зорилт -1: Хэлтсийн мэргэжилтнүүд англи хэлний болон мэргэжлийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх</p>	<p>боловсролоо бие даан гүнзгийрүүлж ажиллаж байна. Хэлтсийн мэргэжилтэн, судлаач, гэрээт ажилтнууд нь бие биенээ эзгүй үед орлож хөрвөж ажиллах чадварыг эзэмшүүлэх зорилгоор хэлтэс дотроо сургалт явуулж ҮСХ-ноос боловсруулсан маягтыг заавар журмын дагуу ашиглахыг бүх л программ дээр дадлагажуулж эзэмшүүлээ.</p> <p>ҮСХ-ноос зохион явуулдаг Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын анхан шатны сургалтанд хэлтсийн мэргэжилтэн А.Наранчимэг хамрагдаж А /93/ үнэлгээ аван сертификат гардан авлаа.</p> <p>2015 оны 4 дугаар сарын 28, 29 - ний өдрүүдэд Чингис хотноо зохион байгуулагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудийн нэгдсэн сургалт зөвлөгөөнд хамрагдсан.</p> <p style="text-align: right;">/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/</p>			
<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх</p> <p>Зорилт-1: Хэнтий аймгийн нийгэм эдийн засгийн статистик үзүүлэлтийг ашиглан шинжилгээ, судалгааны ажил хийх</p>	<p>Хөдөө аж ахуйн салбарын, Ажил эрхлэлтийн , Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдлын , Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын гэсэн 5 танилцуулгыг тус бүр 50 ширхэгийг хийж аймгийн удирдлагууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад тархааснаас гадна цахим хэлбэрээр 290 удаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд тархаасан.</p> <p style="text-align: right;">/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/</p>			
<p>1.5</p>	<p>Төрийн албаны тухай хууль тогтоомж ,стандартыг мөрдөж ажиллана.</p>	<p>Төсвийн шууд захирагчийн хувьд бүтэн жилийн турш төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, байгууллагынхаа үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглаж ажиллаа.</p> <p style="text-align: right;">/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/</p>		

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.БОЛДБААТАР